



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 06 өдөр

Дугаар А/540.

Есөнбулаг

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Боловсролын ерөнхий хуулийн 13.3.2, 30.1.7 дахь заалт Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 78 дугаар тогтоол, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 19 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.1 дэх заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2024 оны улс, олон улсын чанартай олимпиад уралдаан тэмцээнд амжилт гаргасан багш сурагчид болон анги олимпиад, ур чадварын уралдаанд амжилт гаргасан багш, сурагчдын урамшуулалд шаардагдах 1,974,001,670 (нэг тэрбум есэн зуун далан дөрвөн сая нэг мянга зургаан зуун дал) төгрөгийг Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөрийн батлагдсан зардлаас гаргаж аймгийн Боловсролын газар (Д.Энхцэцэг)-т шилжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат) т зөвшөөрсүгэй.

2. Захирамжийн хэрэгжилтийг хангаж, хөрөнгийн зарцуулалтыг тайлагнан ажиллахыг аймгийн Боловсролын газар (Д.Энхцэцэг)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Ж.Амгаланбаатар)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

